

## “Дорнод Авто зам” ХК-ийн 2015 оны үйлдвэрлэлийн ажлын тайлан

“Дорнод Авто зам” ХК нь зэргэлдээх аймгууд болон ОХУ, БНХАУ-тай холбогддог нийт 7 чиглэлд 1250 км улсын чанартай зам, 1296 у/м төмөр бетон гүүрийн бэлэн байдал, зам засвар арчлалтын ажлыг хариуцан ажилладаг.

Тус компани нь 2015 онд үйл ажиллагааны үндсэн чиглэл болох хариуцсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх гэрээг ЗТЯ-тай байгуулж, батлагдсан төлөвлөгөө хөрөнгийн хэмжээнд багтаан зам засвар арчлалтын ажлыг графикт хугацаанд нь технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэлээ.

Ажил эхлэхийн өмнө үйлдвэрлэлийн бэлтгэл ажлыг сайтар хангах, техникийн засвар үйлчилгээг чанартай хийх, тухайн ажилд шаардлагатай материал, сэлбэгээр хангах зэрэг ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан ба ажлын явцад техникийн ноцтой эвдрэл гарч ажил саатах тохиолдол бага гарсан.

Зам Тээврийн Яам, ЗТХТөв зэрэг удирдах дээд газруудын гаргасан тушаал шийдвэр заавар зөвлөмжийг дагаж мөрдөж ажилласан бөгөөд оны эцэст гэрээ дүгнүүлэхэд хангалттай сайн гэсэн үнэлгээ авлаа.

Замын бэлэн байдлыг хангаж, хэрэглэгчдийг замаар ая тухтай зорчуулах тал дээр анхаарч ажилласан бөгөөд цаг агаарын хүндрэлтэй үед шуурхай хэсгийг яаралтай арга хэмжээ авах, Хөлөнбуйрын Шуурхай хэсгийг заагдсан тооны техник, хүн хүчний бүрэлдэхүүнтэйгээр байнгын бэлэн байдалд байлгах, гүүр хамгаалагчдийг зохих журмын дагуу ажиллуулж ирлээ.

2015 онд зам засварын ажлын явцад хуучин Норовлин, Сүмбэр, Хавирга чиглэлүүдэд хуучин хайрган замын даланг засч сайжруулж замыг уртасгах, километрийн тэмдэгийг сэргээх, ус гаргах хоолой тавих зэрэг шинэлэг ажлууд хийгдсэн болно.

Мөн зүүн бүсийн автозамчдын уламжлалт спорт урлагийн арга хэмжээг аймагтаа амжилттай зохион байгууллаа.

Тайлан бичсэн: Т. Үнэнбат